

БАТЛАВ:

БОАЖЯ-ны ХБОБНУГазрын дарга .....А.ЭНХБАТ

ЗӨВШӨӨРЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:

“Түмэн-Эгшиг” ХХК-ны Захирал.....Г.ЧИНЗОРИГ

**ТӨВ АЙМГИЙН СЭРГЭЛЭН СУМЫН НУТАГТ ҮЙЛ АЖИЛЛАГАА  
ЯВУУЛДАГ ТҮМЭН-ЭГШИГ ХХК-ИЙН 2022 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ  
ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

*/Ахуйн нэгжийн регистрийн дугаар 2657457/*

*Хянасан: БОАЖЯ-ны Уул уурхай, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний  
хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн:.....П.Шинэцэцэг*

*Боловсруулсан: “Түмэн-Эгшиг” ХХК-ны мэргэжилтэн.....Г.Алтанчимэг*

УЛААНБААТАР ХОТ

2022он

## **ГАРЧИГ**

- 1.1. Төслийн товч танилцуулга .....
- 1.2. Түмэн-Эгшиг ХХК-ийн эзэмшдэг тусгай зөвшөөрлүүд

## **2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....**

- 2.1. Уур амьсгал.....
- 2.2. Геологийн тогтоц ба геоморфологи .....
- 2.3. Гадаргын ус.....
- 2.4. Газрын доорх ус .....
- 2.5. Хөрсөн бүрхэвч .....
- 2.6. Ургамлан нөмрөг.....
- 2.7. Амьтны аймаг .....
- 2.8. Тусгай хамгаалалттай газар нутаг .....
- 2.9. Нийгэм, эдийн засаг .....

## **3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ**

## **4. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ДАГУУ ХИЙСЭН АЖЛУУД**


- 4.1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт.....
- 4.2. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт.....
- 4.3. Хөрсөн бүрхэвчид учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ төлөвлөгөөний биелэлт .....
- 4.4. Газрын хэвлийд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ төлөвлөгөөний биелэлт .....
- 4.5. Ургамлын аймаг, ургамлан нөмрөгт учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт .....
- 4.6. Амьтны аймагт учруулах сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт.....

5. **ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ**
6. **ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ**
  
7. **УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭ**
  
8. **БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ АЖЛЫН 2022 ОНЫ БИЕЛЭЛТ**
  
9. **ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖЛУУД**
  
10. **БОМТ-НИЙ НИЙТ ЗАРДЛЫН ХҮСНЭГТ, БИЕЛЭЛТИЙН ДҮН**

## 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

“Түмэн Эгшиг” ХХК нь 2005 онд байгуулагдсан ба 2018 оноос химийн хорт болон аюултай бодисын ашиглагдсан сав баглаа боодол болох полиэтилен канистр, торх, ИВС танк, полипропилен уут шуудай, төмөр торх зэргийн хог аюулыг бууруулан хоргүйжүүлж саармагжуулан механик боловсруулалтанд оруулж хоёрдогч түүхий эд бэлтгэн хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэнд оруулж баялаг бүтээх автомат ажиллагаатай эко үйлдвэрийг ашиглалтанд оруулсан.

Манай үйлдвэр нь Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг Налайхын 4 дүгээр зөрлөгийн зүүн талд Налайх-Багахангай чиглэлийн хатуу хучилттай авто замын дагуу байрлах ба 5 га талбайтай.



### Төслийн зорилго

Улаанбаатар хотын хэмжээнд сүүлийн жилүүдэд Нарангийн энгэр, Морингийн даваа, Цагаан даюаа гэсэн төвлөрсөн хогийн цэгүүдэд жилд 1,4 сая тонн хог хаягдлыг хаяж байна. Үүнээс жилдээ 29-58 мянган тонн аюултай хог хаягдал гаргадаг. Ялангуяа үйлдвэрлэл үйлчилгээний салбар бүрийн химийн бодисын хэрэглээ нэмэгдэж байгаатай зэрэгцэн гарч буй тэдгээрийн сав баглаа боодлын хаягдалын хэмжээ нэмэгдсээр байна. ДЭМБ-ын санхүүжилтээр “Хордлого судлал, эрдэм шинжилгээний нийгэмлэг”-ээс 3 аймаг, Улаанбаатар хотын 297 өрхийг 2015 онд хамруулан явуулсан судалгаагаар хотод нийт өрхийн 54%, орон нутагт 80 гаруй хувь нь хүнсний бүтээгдэхүүн хадгалах зорилгоор нэг өрх дунджаар 20-100 литрийн багтаамжтай 3-4 ширхэг зориулалтын бус хуванцар сав ашигладаг гэсэн дүн гарчээ. Мэргэжлийн хяналтын байгууллагын шинжилгээгээр хүнсний зориулалтын бус хуванцар саванд хонуулсан усны найрлагыг төвлөрсөн сүлжээний усны үзүүлэлттэй харьцуулахад

## 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

төмөр 2 дахин, нитрит 11 дахин, аммиак 48 дахин их, хуванцар саванд хонуулсан сүүнд хүнд металл кадмийн агууламж стандартад заасан зөвшөөрөгдөх хэмжээнээс 3-4 дахин, айрганд 4,4 дахин их, хар тугалга 3 дахин их байгааг тогтоожээ.

Химийн бодис, бүтээгдэхүүний сав баглаа боодол нь Монгол Улсын “Хог хаягдлын тухай хууль” болон “Аюул учруулах барааны эсрэг хамгаалалт, Химийн хорт бодисын хаягдлыг устгахад тавих шаардлага MNS 5479-2005 6х” стандартаар дахин хэрэглэж болохгүй хог хаягдал, ялангуяа хүний эрүүл мэндэд хортой бодис бүтээгдэхүүн, цемент, будаг, гоо сайхны сав баглаа боодлын хаягдал асар хурдацтай ихэсч байгаа тул эдгээр сав баглаа боодлыг хоргүйжүүлэх, устгах, дахин боловсруулж, хоёрдогч түүхий эд болгох, улмаар бүтээгдэхүүн үйлдвэрлэх нь хойшлуулшгүй шаардлага бий болоод байна.

Ийм учраас “ТҮМЭН ЭГШИГ” ХХК нь аюултай хог хаягдлын хор аюулын хэмжээг бууруулах, устгах ажлыг мэргэжлийн түвшинд гүйцэтгэн хүн амын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинг хамгаалах ажилд өөрсдийн хувь нэмрийг оруулах зорилгоор энэхүү төслийг санаачилсан

### Үйлдвэрийн хүчин чадал

Үйлдвэрийн хүчин чадлын хувьд 1 цагт 300 кг, өдөрт 1800 кг шуудай дахин боловсруулах ба хуванцар, химийн бодисын бохирдолтой сав, полиэтилен канистр, торх, ИВС танк зэрэг хуванцарыг 1 цагт 500 кг, өдөрт 4 тн-г боловсруулах хүчин чадалтай. Эдгээрийг хаягдал тус бүрээр тооцвол өдөрт 1500 ш канистр, 400ш торх, 258ш ИВС танк болно.



Зураг 1 Үйлдвэрийн барилга байгууламжийн зураг



## ХУВАНЦАР САВ БАГЛАА БООДОЛ ДАХИН БОЛОВСРУУЛАХ ТЕХНОЛОГИ

Хоёрдогч хуванцарын түүхий эдийн үйлдвэрлэл нь ашиглагдсан химийн бодис, материалын сав, шуудай, ууцыг туузан дамжуургаар дамжуулан бутлах машинд оруулан бутлах явцад химийн аргаар саармагжуулах, тунадасжуулах, ангижруулах аргыг хэрэглэн химийн хорт болон аюултай бодисоос салгаж тэдгээрийн физик, химийн шинж чанарыг хувиргахгүйгээр механик боловсруулалт хийж, хэлбэр дүрсийг нь өөрчлөн түүхий эд болгон дахин боловсруулна.



Агуулахын барилга байгууламж



Хуванцар дахин боловсруулах үйлдвэрийн тоног төхөөрөмж



Тэсэлгээний бодисын шуудай дахин боловсруулах тоног төхөөрөмж

---

1.2 ТҮМЭН-ЭГШИГ ХХК-ИЙН ЭЗЭМШДЭГ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛҮҮД

Манай компани нь Аюултай хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэх 0000022 дугаартай тусгай зөвшөөрлийг 2022 оны 04 сарын 20нд БОАЖЯамнаас авсан.

Газар эзэмших эрхийн гэрчилгээг Төв аймгийн Сэргэлэн сумын Засаг даргын захирамжаар 4109051673 нэгж талбарын дугаартай 5 га газрыг Үйлдвэрийн барилга байгууламж, бусад газрын зориулалтаар 2019 онд авсан.

Барилгын талбайн инженер геологийн судалгааг “Ланд тест” ХХК-р хийлгэж Барилгын Хөгжлийн Төвөөр батлуулсан.

Үйлдвэрийн барилгын зураг төслийг “Гео констракшн” ХХК-р гүйцэтгүүлж Төв аймгийн Ерөнхий архитектороор батлуулж холбогдох зөвшөөрлийг авсан.

Улаанбаатар Цахилагаан түгээх Сүлжээ төрийн өмчит хувьцаат компаниас Цахилгааны шугам сүлжээний техникийн нөхцөлийн зөвшөөрлийг авч баталгаажуулсан.

Төв аймгийн БОАЖГазраас гүний худаг гаргах зөвшөөрлийг авсан.

Төв аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газраас Барилгын ажлын зөвшөөрлийг авсан.

Үйлдвэрийн Байгаль Орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг “Цавчирын хөндий” ХХК-р гүйцэтгүүлж БОАЖЯ-р батлуулсан.

Үйлдвэрийн Байгаль Орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг Төв аймгийн Сэргэлэн сумын 1-р багийн иргэдэд танилцуулж зөвшөөрөл авсан ба Багийн ИНХ-н тогтоол холбогдох зөвшөөрлийг авсан.

Газар ашиглах болон ус ашиглах гэрээг орон нутагтай байгуулан сумын Засаг даргаар батлуулсан.

Усны дүгнэлт, Галын аюулгүй байдлын дүгнэлт зэргийг холбогдох газруудаас авсан.

Химийн бодисын агуулахын ажлын байрны дүгнэлтийг холбогдох газруудаас авсан

## 2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### 2.1 Уур амьсгал

Уур амьсгалын хувьд Монгол орны бусад газар нутгийн нэгэн ижил эх газрын эрс тэс шинжтэй. Өргөрөгт жилдээ хэвтээ гадаргад  $4780 \text{ мДж/м}^2$  орчим хэмжээний нийлбэр цацраг, мөн  $2720 \text{ мДж/м}^2$  шулуун цацраг тус тус ирнэ. Нарны цацраг жилийн турш хэлбэлзэл ихтэй, нарны өндөр хамгийн бага байх 12 дугаар сард нийлбэр цацраг  $140 \text{ мДж/м}^2$ , нарны өндөр хамгийн ихсэх 5 дугаар сард  $625 \text{ мДж/м}^2$  (6 дугаар сарын 15-нд жин үдэд нар хамгийн өндөр  $65^\circ$  болдог ч доод мандлын үүлшлээс хамааран  $620 \text{ мДж/м}^2$ ) болж намар цацрагуудын хэмжээ буурдаг зүй тогтолтой.

Олон жилийн дунджаар агаарын температур  $-2^\circ\text{C}$ - $3^\circ\text{C}$  хамгийн хүйтэн өвлийн улирлын нэгдүгээр сард  $-25^\circ\text{C}$ - $27^\circ\text{C}$ , үнэмлэхүй хамгийн хүйтэн  $-40^\circ\text{C}$ - $46^\circ\text{C}$  хүрч хүйтэрдэг. Өвлийн төгсгөлөөс аажим дулаарч, хаврын 4 дүгээр сард  $+0^\circ\text{C}$  орчим дулаарч, улмаар эрчимтэй дулааран зуны горимд шилжих ба 7 дугаар сард  $+17^\circ\text{C}$  дулаарч, хамгийн халуун  $35^\circ\text{C}$ - $39^\circ\text{C}$  хүрээд, цаашид сэрүүсч, 10 дугаар сард  $-1^\circ\text{C}$  болж улмаар хүйтэрнэ.

Хөрсний гадаргад жилийн дунджаар агаарынхаас  $2^\circ\text{C}$  - $4^\circ\text{C}$  дулаан байх бөгөөд өвлийн саруудад  $2^\circ\text{C}$  - $3^\circ\text{C}$  хүйтэн, зуны саруудад  $4^\circ\text{C}$  - $7^\circ\text{C}$  дулаан байдаг зүй тогтолтой.

Энэ бүс нутагт жилийн дундаж агаарын даралт 830 гПа байх бөгөөд өвлийн саруудад 828-858 гПа, зуны саруудад 825-828 гПа болж хэлбэлзэл бага байх боловч, цаг агаар солигдох үед ихээхэн хэлбэлздэг. Агаарын даралтын тогтолцоо уул, хөндий, тал газар нутгийн онцлогоос хамааран салхины горим илэрч, их даралттай орноос бага даралттай орон зай руу агаарын урсгал буюу салхи үүсч байдаг. Салхины дундаж хурд 3-4м/с, хамгийн ихдээ 24- 34м/с хүрнэ.

Жилийн дунджаар агаарын харьцангуй чийгшил 61-67%, мөн "чийглэгдүү" буюу хүн, техникт харьцангуй тохиромжтой байх боловч, хаврын саруудад хуурайшиж, 50-55%, намар 52-60%, өвлийн саруудад даруй ихэсч 70-80% болж нэмэгддэг зүй тогтлоор хувьсч байдаг. Төсөл хэрэгжих бүс нутагт хур тунадасны зуны горимтой бөгөөд жилд 240-250 мм хур тунадас ордогдоос 97% орчим нь дулааны улиралд, үүнээс зуны 3 сард 75-80% ордог.

### 2.2 Геологийн тогтоц ба геоморфологи

Д.Болд, Д.Гансүх нарын 1996-1997 онуудад хийсэн Улаанбаатар хот орчмын нутаг дэвсгэрийн геологийн тогтцыг сансрын SPOT хиймэл дагуулын мэдээлэлд тулгуурлан судалсан ажлын үр дүнг ашиглан орд орчмын геологийн тогтоц бүлгийг бичиж, орд орчмын геологийн зургийг хэсэгчлэн авч үзлээ. Ордын районд дунд палеозойн болон мезо-кайнозойн тунамал чулуулаг маш өргөн тархсан бөгөөд талбайн нам болон хотгор хэсгээр дээд дөрөвдөгч-орчин үеийн сэвсгэр хурдас тархсан байна.

#### Давхаргазүй:

- Доод-дунд девоны горхийн свит (O—дг)
- Доод-дунд карбоны Алтан-Овоогийн давхраадас: (C<sub>1-2</sub>)
- Доод цэрдийн Зүүнбаянгийн давхраадас (K<sub>1-2b</sub>)
- Дээд неоген, плиоцены хурдас (N)
- Дөрөвдөгчийн хурдас (O—O<sub>iv</sub>)

Улаанбаатар хот орчмын тектоник хагарал нь гол төлөв гүний хагарлаар тодорхойлогдох ба



газар хөдлөлийн 6-7 баллын чичирхийллийн бүсэд оршино.

### 2.3 Гадаргын ус

Төслийн талбай нь Дэлхийн ус хагалбарын Хойд мөсөн далайн ай савд, Туул голын сав газарт хамаарагддаг. Төслийн талбайд хамгийн ой орших гадаргын усны томоохон илэрц нь Туул гол юм. Туул голын дундаж урсац 20м<sup>3</sup>/сек. Туул гол нь хаврын шар усны болон зуны хур борооны үерийн үед буюу 4 дүгээр сарын дунд үеэс 9 дүгээр сарын сүүл хүртэл их устай байдаг. Гачиг үе 10-р сарын сүүлээс 4 дүгээр сарын эхэн хүртэл ажиглагдана. Урсацын 70% нь хур борооны, 25% нь ул хөрсний, 5% нь хайлсан цасны уснаас бүрдэнэ. Тус нутгаар урсан өнгөрөх голууд нь гол мөрний горимын ангиллаар хаврын шар усны ба зуны хур борооны үертэй голуудад хамаарна.

Төслийн талбайд хамгийн ойр Найлайхын<sup>1</sup> гол, Дэндийн голын Туул гол руу цутгаж байгаа хэсгийг авч үзвэл Налайхын гол нь анион, катионы хувьд хамгийн өндөр агууламжтай бохирдолт болон хуурай үлдэгдэл ихтэй бөгөөд химийн бүрэлдэхүүнээр авч үзвэл гидрокарбонат ангийн, кальцийн бүлгийн, 1 төрлийн, цэнгэгдүү, зөөлөвтөр ус байна. Өргөн нь ойролцоогоор 2.5м, гүн нь 0.5м, урсгалын хурд нь 0.92м/с байна.

### 2.4 Газар доорх ус

Гидрогеологийн нөхцөл нь дөрөвдөгчийн настай төрөл бүрийн хурдас дахь ул хөрсний ус байдаг ба гадаргын хотгор гүдгэрт эзэлж буй байршил, газрын доорхи чулуулгийн шинж чанараас шалтгаалан эзлэх талбай болон гүний хувьд өөр ба үндсэн хурдасны төрлөөр нь тодорхойлдог онцлогтой.

Туул голын сав газар дахь газар доорхи усыг чулуулгын гарал үүслээр нь дараах уст давхаргуудад хуваажээ.

**Орчин үеийн дөрөвдөгчийн аллюви, пролювийн уст горизонтод (арО,у):** Туул голын хөндий, түүнд салбарлаж нийлдэг Оолгойт, Сэлбэ, Улиастайн голуудын цутгал хамаарна. Уст үеийн ерөнхий зузаан 50-60 м боловч татмын өндөр дэнжи 5-10 м болдог. Газар доорхи ус нь зуны улиралд газрын гадаргаас 0.5 -4.0 метрийн гүнд 1245-1320 м-ийн үнэмлэхүй өндөрт харгалзах түвшинд илэрдэг.

**Дунд-дээд дөрөвдөгчийн орчин үеийн аллюви, пролюви, делюви-пролювийн хурдасны уст горизонтод** туул голын хөндийд салбарлаж байгаа толгойт, сэлбэ, улиастай, залаатын ам, яармагийн дэнж орчмын хэсэг хамаарагдана. Толгойт голын хөндийн хэмжээнд уст үеийн зузаан 18-30 м, алаг цоог тархалттай олон жилийн цэвдэг чулуулаг дээр 1.0-3.0 м болдог. Грунт усны түвшний дээд хил газрын гадаргуугаас 0.5-7.4 м-ийн гүнээс илрэх бөгөөд зарим хэсэгтээ өвөл зуны улиралд бага зэрэг даралттай байдалтай (0.5-2.0 м) болдог онцлогтой.

**Доод цэрдийн нуурын хурдасны уст комплекс (к):** талбайн баруун хойт хэсэг ХХ1 хорооллын зүүн талд зурвас байдлаар тархсан. Ус агуулагч хурдас нь ногоон саарал өнгийн шавранцар янз бүрийн хэмхдэс агуулсан заримдаа конгломератын нарийн үетэй болно. Уг комплексийн дөрөвдөгчийн сэвсгэр хурдсаар хучигдсан хэсэгт (Туул голын хөндийн) уст

<sup>1</sup> Улаанбаатар хотын ус хангамжийн эх үүсвэрүүд, Туул гол, гадаргын усны харилцан хамаарал ба хяналт-шинжилгээний сүлжээний байгуулалт. Судалгааны ажил

горизонт 34-42 м-ийн гүнээс хэдэн арван метрийн зузаантай илрэх бөгөөд ус нь нилээд эрдэсжсэнээрээ ялгагдана.

**Палезойн тунамал чулуулгийн уст комплекс (Ө):** нь туулын голын хөндийн дагуу толболог байдалтай тархсан. Ус агуулагч чулуулаг нь ан цавархаг үелэг тогтоцтой алевролит, аргеллит, шаварлаг занар ховроор элсэн чулуу болно. Уг уст комплекс газрын гадаргаас 34 - 70 м-ийн гүнд тохиолдох бөгөөд зарим тохиолдолд рельефийн нам хэсгээр булаг байдлаар илэрнэ. VII сард 1.0-2.0 л/ж гэж зарим судалгааны материалд тусгагдсан байна.

Хээрийн судалгааны ажлын үеэр төслийн талбайд ойр орших аж ахуйн нэгж байгууллагуудын ашиглаж буй гүний худгын уснаас нийт 3 дээж авч ерөнхий химийн шинжилгээг хийлгэсэн. Шинжилгээний үр дүнгээс харахад газрын доорх ус нь гидрокарбонат бүлгийн, кальцийн анги, магни, нитрат ионы агууламжаас хамаарч 2-р төрлийн, зөөлөвтөр ус болох нь ажиглагдав. Усны төрлийн хувьд Ахуйн худаг нь  $\text{Ca}(\text{HCO}_3)$  төрлийнх, Үйлдвэрийн худаг нь  $\text{Ca}(\text{HCO}_3)$  төрлийн, Диваажингийн хүрээлэнгийн худаг нь  $\text{Ca}(\text{HCO}_3)$  төрлийн ус байна. Ерөнхийдөө худгууд нь ижил төрлийн найрлагатай боловч шинж чанар болон тэжээгдлийн нөхцөлөөс хамаарч өөрчлөгдөх магадлалтай байна.

### 2.5 Хөрсөн бүрхэвч

Төслийн талбайн хувьд Уулын хөрсний ангилалын хүрэн хөрсний дэд хэв шинжийн уулын хар хүрэн хөрсний тархалттай хэсэгт багтаж байна.

Судалгааны талбайд хийсэн хээрийн хэмжилтээр авч бэлтгэсэн дээжинд хийсэн лабораторийн задлан шинжилгээний дүнгээс үзэхэд А үе давхаргын хөрсний урвалын орчин буюу сул шүлтлэг, ялзмагийн агууламж 1.45 %,  $\text{CaCO}_3$  агууламж 0.04 %, хөдөлгөөнт суурийн ( $\text{P}_2\text{O}_5 + \text{K}_2\text{O}$ ) нийлбэр 27.1 мг/100гр, калийн исэл зонхилно. Хялбар уусах давс агууламжийн хувьд 0.092 dS/m орчим буюу давсны агууламж багатай байна. Тухайн цэгийн хөрсний В үед давхаргын хувьд урвалын орчин 7.9 буюу шүлтлэг, ялзмагийн агууламж 0.43 %,  $\text{CaCO}_3$  агууламж 0.05 %, хөдөлгөөнт суурийн ( $\text{P}_2\text{O}_5 + \text{K}_2\text{O}$ ) нийлбэр 11.7 мг/100гр, Калийн исэл зонхилно. Хялбар уусах давсны агууламжийн хувьд 0.106 dS/m орчим буюу давсны агууламж багатай байна. Фикик шинж чанарын хувьд шавранцар хүнд элементийн агууламжийн хувьд Никель, кадми, хром, зэс тодорхойлогдоогүй, хар тугалгын агууламж 6.0 мг/кг, цайрын агууламж 19.1 мг/кг буюу MNS 5850:2008 стандартыг давсан үзүүлэлтгүй байна.

Төслийн талбайн хойд хэсгээр үйлдвэрлүү явсан шороон зам үүсгэсэн болон инженер геологийн судалгаагаар ухсан нүхийг эргүүлэн булаагүй зэрэг эвдрэл нөлөөлөл байсан боловч энэ нь төдийлөн их талбайг хамраагүй байна.

### 2.6 Ургамалан нөмрөг

Төслийн талбай нь Уулын ойт хээрийн ургамалжилтын бүсэд хамаарагдана. Тус талбайн ургамалжилт өнөөгийн байдлаар ашиглалтын нөлөөнд өртөөгүй бөгөөд ургамлын аймаг, ургамалжилтын судалгааны үр дүнд төслийн талбай бүхэлдээ нэг хэвшинжид хамаарагдах *Алаг өвс-агь-үетэнт /У-V-2-1/ бүлгэмдэл* тархсан байна. Ургамалжлын зүйлийн бүрэлдэхүүний хувьд 12 овгийн 25 төрлийн нийт 29 зүйл ургамал бүртгэгдсэн. Эдгээр ургамал нь амьдралын хэлбэрийн хувьд сөөг-1, сөөглөг-1, сөөгөнцөр-1, сөөгөнцөрлөг-2, олон наст өвс-18, хоёр наст-1, нэг наст-5 зүйл ургамал тус тус тэмдэглэгдсэн. Судалгааны талбайд бэлчээр, тэжээлийн үнэт ургамал *Stipa sibirica*-сибирь Хялгана, *Stipa krylovii*-крыловын Хялгана,

*Cleistogenes squarrosa-дэрвээн* Хазаар өвс, *Koeleria macrantha* -том цэцэгт Дааган сүүл зэрэг зүйл ургамлууд зр үнэлгээтэйгээр тэмдэглэгдсэн.

### 2.7 Амьтны аймаг

Төслийн талбайн нь Монгол орны хөхтөн амьтдын газарзүйн мужлал (Банников, 1954)-аар Хойт доод муж, тайгын провинци, Хэнтий, Монгол Дагуурын хээрийн тойргуудад хамаарна. Хээрийн судалгааны үед төслийн талбай орчимд хөхтөнөөс мах идэштний багаас 2 зүйл амьтан, шавж идэштний багаас 1 зүйл, туулай хэлбэртний багаас 1 зүйл, мэрэгчдийн багаас 3 зүйл, гар далавчтаны багаас 1 зүйл, шувуудаас 6 багийн 18 зүйл шувууд бүртгэгдсэнээс 9 зүйл нь нүүдлийн буюу улирлын байдлаар нүүдэллэдэг, 9 зүйл нь суурин амьдралтай шувууд байна. Тухайн бүс нутагт тархан амьдарч байгаа амьтдаас 5 зүйл нь агнуурын ач холбогдолтой, Монгол орны хөхтөн амьтдын Улаан дансанд бүртгэгдсэн байдлаар тус газар орчимд тархсан зүйлүүдээс 7 зүйл нь “Анхааралд өртөхөөргүй” ангилалд, 1 зүйл буюу хярс үнэг нь “Ховордож болзошгүй” гэсэн ангилалд тус тус бүртгэгджээ.

Тус газар нутаг нь төвлөрсөн хот суурин газартай ойролцоо байршиж байгаа учир хөхтөн амьтдын популяци, тоо толгойн байдалд хомс, амьтдын зүйлийн бүрдэл ядмаг байна.

### 2.8 Тусгай хамгаалалттай газар нутаг

Төслийн талбайд хамгийн ойр тусгай хамгаалалттай газар нутаг нь Богдхан уулын ДЦ газар 5.5км, Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газар 15км тус тус оршино. Богдхан уулын ДЦ газар нутаг нь байгалийн олон бүс бүслүүрийн хэв шинжийг агуулсан биологийн төрөл зүйлээр нэн элбэг юм.

### 2.9 Нийгэм эдийн засаг

Сэргэлэн сум нь 2018 оны байдлаар 815 өрхийн 2105 хүн амтай. Хүн амын 440 малтай өрх, 592 малчинтай, 140.9мян.малтай байна. Сумын нийт газар нутгын 91.8 хувийг хөдөө аж ахуйн газар, 1.27 хувь ойн сан бүхий газар, 0.08 хувь нь усан сан бүхий газар, 4,71 хувийг тусгай хэрэгцээний газар, 1.25 хувийг тосгон, суурингийн газар, 0.89 дэд бүтцийн газар хамаарч байна.

Сумын хэмжээнд нийт 56 аж ахуйн нэгж байгууллага үйл ажиллагаа явуулж 10,1тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж улсад 30.6 сая, аймагт 150,3 сая, орон нутагт 80,9 сая нийт 2090.0 сая төгрөгийн татвар төвлөрүүлж байна.

### 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

#### Агаарын чанарт үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөллүүд

Төслийн үйл ажиллагаанаас агаар орчинд үзүүлэх гол сөрөг нөлөөлөл нь үйлдвэрийн талбайн эвдрэлд өртсөн сул хөрс, шороон замаас тоосжилт үүсэх, үйлдвэрийн тээврийн хэрэгслүүдийн хөдөлгүүрээс агаарт хийн хаягдал үүсэх, хог хаягдал шатаах зуухны шаталтаас хийн хаягдал үүсэх зэрэг байна.

#### Нөлөөлөлд өртөгчид:

Төслийн үйл ажиллагааны улмаас үүсэх агаарын бохирдол /тээврийн хэрэгслийн хөдөлгүүрээс ялгарах хорт хий, зуухны шаталтаас үүсэх хийн хаягдал/, тоосжилтын нөлөөлөлд шууд болон шууд бусаар өртөж болзошгүй субектууд нь :

- Ойр орчныг хүрээлэн буй орчин
- Үйлдвэрийн ажилчид, /нөлөөллийн тархалтын цар хүрээнээс хамаарч төслийн талбайд ойр орших суурин газрын иргэд/

Төслийн үйл ажиллагаанаас үүсэж буй тоосжилт болон хаягдал хийн хэмжээ стандарт агууламжаас давсан тохиолдолд хүний эрүүл мэнд болон байгаль орчинд сөргөөр нөлөөлж болзошгүй юм. Энэ талаар дэлгэрэнгүй авч үзвэл:

#### Тоосжилтоос хүний биед үзүүлэх сөрөг нөлөөлөл

Стандарт агууламжаас давсан тоосжилт бүхий орчинд байсанаар:

- Ажилчдын хамрын салст гэмтэх
- Нүдний бүрхэвчид сөргөөр нөлөөлөх
- Уушгинд сөргөөр нөлөөлөх: бронхит, багтраа, астам зэрэг өвчнөөр өвчлөх зэрэг болно.

#### Хорт хийнээс хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөлөл

Үйлдвэрийн үйл ажиллагаанд ашиглах техник хэрэгслүүдээс агаарт цацагдах хортой хий бүхий утаа тортог нь ихэвчлэн техник хэрэгслүүдийн хөдөлгүүр дэх бензин, дизель түлшний дутуу шаталтаар бий болно. Үүнд хамгийн нийтлэг бохирдуулагчид CO<sub>2</sub>, NO<sub>2</sub>, хөө- утаа тортог орно.

Бензинээр ажилладаг хөдөлгүүрт:

1. Нүүрстөрөгчийн дутуу исэл CO<sub>2</sub>
2. Азотын ислүүд NO<sub>2</sub>

Дизель хөдөлгүүрт:

- Нүүрстөрөгч CO<sub>2</sub>
- Азотын ислүүд NO<sub>2</sub>
- Хөө тортгийн агууламжаар тус тус тодорхойлно.

Тээврийн хэрэгслийн хөдөлгүүр дэх түлшний дутуу шаталтаас агаарт ялгарах хортой хийн гол хувийг эзэлдэг хортой нэгдлүүдийн тухай авч үзвэл.

- Азотын исэл (NO<sub>2</sub>) нь нэлээн хэдэн өдрөөр арилахгүй хуримтлагдаж агаарт исэл бүрэлдэхэд гол үүрэг гүйцэтгэдэг. Энэ нь хүн ба ургамал, амьтан амьсгалахад нөлөөлдөг.
- Нүүрс устөрөгч (C<sub>n</sub>H<sub>2n+2</sub>) нь бензин шатахуун дутуу шатах болон тэдгээрийн ууршилтаас үүсдэг ба химийн олон янзын органик бодисыг агуулж байдгаас эрүүл мэндийг хордуулах, цочроох, хорт хавдар үүсгэх зэрэг олон төрлийн нөлөө үзүүлэг.
- Нүүрстөрөгчийн дан исэл (CO) нь агаарт нэгээс хоёр сар хүртэл хуримтлагддаг ба хүний цусан дахь гемоглобинтой нэгдэхээрээ түүний хүчилтөрөгч зөөх үүргийг нь алдагдуулдаг байна.

## 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

Бага хэмжээтэй үед толгой эргэх, өвдөх, мэдрэх эрхтний ажиллагааг алдагдуулах зэрэг нөлөө үзүүлдэг бол их хэмжээтэй үед амьсгал боогдсоноос мэдрэлийн эрхтэнд хүчтэй нөлөөлдөг байна. Дизелийн түлшээр ажилладаг хөдөлгүүр нь бензинээр ажилладаг хөдөлгүүртэй харьцуулахад нүүрстөрөгчийн дан исэл болон нүүрс устөрөгчийг арай бага ялгаруулдаг.

- Хүхрийн давхар исэл (SO<sub>2</sub>) нь агаарт хэдэн цагаас хэдэн долоо хоног хүртэл хуримтлагдах ба ялгарах хэмжээ нь шатахуунд агуулагдаж байгаа хүхэртэй шууд хамааралтай байдаг. Энэ исэл нь амьсгалын замын эрхтнийг цочроох үйлчилгээтэй бөгөөд түүнийг агуулсан хүчиллэг бороо нь ургамал, ус, бусад материалыг хордуулдаг.
- Жижиг ширхэглэлтэй бодист дизелийн түлшнээс гарах ширхэглэлүүд, үрэлтээр дугуйны резинээс элэгдэх хэсэг, хүнд металл болон тоос зэргийг хамруулж үздэг. Эдгээр нь хүний нүд, амьсгалын эрхтнийг цочроож харшил, хорт хавдар үүсгэх нөлөөтэй.
- Хар тугалгыг (Pb) шатахуун дахь октаны хэмжээг ихэсгэх, хөдөлгүүрийн тосолгоонд туслах зорилгоор нэмдэг. Энэ нь мэдрэлийн үйл ажиллагааг алдагдуулах (ялангуяа хүүхдийн), цус багасгах нөлөөтэй. Агаарт хаягдаж буй хар тугалга нь шууд амьсгалаар юмуу эсвэл ундны ус, хүнсний ногоогоор дамжин хүний биед ордог байна.

### Агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл

Төслийн үйл ажиллагаанаас агаар орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөллүүдийг дараах хүснэгтэд нэгтгэн үнэллээ. Хүснэгт 5.3

Төслөөс агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн үнэлгээ

Агаар орчинд учруулах сөрөг нөлөө	Эрчим	Үргэлжлэх хугацаа	Хамрах хүрээ	Магдалал	Нийг оноо	Онооны эзлэх хувь "	Нөлөөллийн зэрэг
<b>Болзошгүй сөрөг нөлөөлөл</b>							
Үйлдвэрийн талбайн эвдрэл, элэгдэлд өртсөн газрын гадарга, шороон замаас тоосжилт үүсэх	4	2	1	3	10	40	Дунд
Тээврийн хэрэгслүүдийн хөдөлгүүрээс гарах хийн хаягдлаар агаар орчин бохирдох	4	2	1	4	11	44	Дунд
Хог хаягдлыг ил задгай хаях, удаан хугацаанд хуримтлуулах зэргээс нян бактери үржин агаар орчныг бохирдуулах	4	1	1	2	8	36	Бага
Хог хаягдал шатаах зуухны шаталтаас үүсэх хийн хаягдлаас агаар орчин бохирдох	6	2	1	3	12	48	Дунд
<b>Үр дүн (ерөнхий дундаж)</b>						<b>42.0</b>	<b>Дунд</b>

Төслөөс агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл 42% буюу дунд зэрэг нөлөөлөлтэй байна. Агаар орчинд үзүүлэх нөлөөллүүд нь 100% болзошгүй сөрөг нөлөөлөл бөгөөд үргэлжлэх хугацаа богино, тухайн орчны хэмжээнд бий болох магадлал дунд зэрэг байна



**Газрын гадарга, хэвлийд учруулах гол ба болзошгүй сөрөг нөлөөллүүд**

Төслийн үйл ажиллагаа эхэлсэнээр 4.9 га талбайн газрын гадарга өөрчлөгдөн ландшафтийн талбайн газрын хэвлий эвдрэл нөлөөлөлд өртөнө.

**Төслөөс газрын гадарга, хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөлийн үнэлгээ**

Газрын гадарга, хэвлийд учруулах сөрөг нөлөөлөл	Эрчим	Үргэлжлэх хугацаа	Хамрах хүрээ	Магдлал	Нийт оноо	Онооны эзлэх хувь %	Нөлөөлийн зэрэг
<b>Гол нөлөөлөл</b>							
4.9 га талбайн гадаргын төрх өөрчлөгдөн барилга байгууламж баригдан, ногоон байгууламж хийгдэнэ	4	3	1	5	13	52	Дунд
2878.36м2 талбайн газрын хэвлий эвдрэлд өртөх	4	3	1	4	12	48	Дунд
<b>Болзошгүй нөлөөлөл</b>							
Үйлдвэрийн болон ахуйн хатуу, шингэн хог хаягдлыг зохих хууль, дүрмийн дагуу зайлуулаагүйгээс газрын гадарга хэвлийг бохирдуулах	6	2	1	2	11	44	Дунд
<b>Үр дүн (срөнхий дундаж)</b>						<b>48</b>	<b>Дунд</b>

Төслийн үйл ажиллагаанаас газрын гадарга болон хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөллийн хэмжээ 48% буюу дунд зэрэг байна.

**Гадаргын болон газар доорх усанд үзүүлэх сөрөг нөлөөлөл**

**Төслийн ус ашиглалт**

**Унд, ахуйн усны хэрэглээ:** Төслийн үйл ажиллагаа нь жилийн дөрвөн улиралд 355 хоног ажиллах бөгөөд үйлдвэрт 43 хүн ажиллана. Нэг хүний хоногийн усны хэрэглээг Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн А/301 дугаар тушаалын 12 дугаар хавсралтаар нэг ажилчны ээлжинд буюу ажлын байранд хэрэглэх халуун болон хүйтэн усны хэрэглээ 20-200л/хон байна. Дараахи тооцоонд нэг хүний хоногт хэрэглэх усны хэмжээг 150л-ээр тооцоход хоногт 6.45м3, жилд 2289,7м3 ашиглах бөгөөд энэхүү хэрэгцээг хангахад 0.18л/сек ундаргатай худгийн усны эх үүсвэрийг ашиглана.

**Унд, ахуйн усны хэрэглээ**

Ажилчдын тоо	Усны хэрэглээ, хүн.м3/хон ог	Ажиллах хугацаа, хоног	Хоногт шаардлагатай усны хэмжээ, м3	Жилд шаардлагатай усны хэмжээ, м3	Нийт хугацаанд ашиглах усны хэмжээ, м3	Шаардлага тай ундарага, л/сек
43	0.15	155	6,45	2289,7	11448,7	0,07

Ъ

Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл

Хэлбэр	Эрчим	Үргэлжлэх хугаана	Хамрах хүрээ	Магадлал	Нийт оноо	Онооны эзлэх хувь %	Нөлөөллийн зэрэг
<b>Гол сөрөг нөлөөлөл</b>							
Үйлдвэрийн үйл ажиллагааны явцад унд ахуйн болон үйлдвэрийн зориулалтаар хоногт 11,45м3 ус ашиглан газрын доорх усны нөөцөд нөлөөлөх	4	3	1	4	12	48	Дунд
<b>Болзошгүй сөрөг нөлөөлөл</b>							
Гүний усны эх үүсвэрийн аюулгүй байдлыг бүрэн хангаагүйгээс газрын доорх усыг бохирдуулах	6	2	1	2	11	44	Дунд
Үйлдвэрийн болон ахуйн шингэн хаягдлыг хөрсөнд алдсанаас хөрсөөр дамжин гүний усыг бохирдуулах	6	2	1	2	11	44	Дунд
<b>Үр дүн (ерөнхий дундаж)</b>						45.3	Дунд

Төслийн үйл ажиллагаанаас усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл дунд зэрэг байна. Нийт 3 нөлөөллийг авч үзсэнээс 1 нь гол сөрөг нөлөөлөл 2 нь болзошгүй сөрөг нөлөөлөл байна.

**Төслийн үйл ажиллагаанаас хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл**

Химийн хорт болон аюултай бодисын сав баглаа боодлын хаягдал дахин боловсруулах үйлдвэр, үйлчилгээний цогцолбор байгуулах төслийн үйл ажиллагааны үед 4.9га талбайн хөрсөн бүрхэвч эвдрэлд өртөж ургамлан нөмрөг устана. Мөн төслийн үйл ажиллагааны явцад ажилчдын санамсар болгоомжгүй байдал болон төслийн төлөвлөлт, байгалийн гэнэтийн гамшигт үзэгдлийн үед хөрсөн бүрхэвч болон ургамлан нөмрөгт дараах сөрөг нөлөөллүүд учирч болзошгүй байна.

Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийн үнэлгээ

Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөлөл	Эрчим	Үргэлжлэх хугаана	Хамрах хүрээ	Магадлал	Нийт оноо	Онооны эзлэх хувь %	Нөлөөллийн зэрэг
<b>Гол сөрөг нөлөөлөл</b>							
Үйлдвэрийн барилга байгууламжийг барих ажлын үед 4.9 га талбайн хөрсөн бүрхэвч эвдрэлд өртөн ургамлан нөмрөг устана	8	2	1	4	13	60	Дунд
Үйлдвэрийн барилгын үйл ажиллагаа эхэлсэнээр үйлдвэрийн талбайгаас хатуу хучилттай авто зам хүртэлх 60м шороон зам бий болж хөрс эвдрэлд өртөн ургамлан нөмрөг устана	8	2	1	4	13	60	Дунд
<b>Болзошгүй сөрөг нөлөөлөл</b>							
Үйлдвэрийн болон ахуйн хатуу, шингэн хог хаягдлыг ил задгай хаях, хаягдал цуглуулах савны битүүмжлэл алдагдсанаас хөрсөн бүрхэвч бохирдох	6	2	1	3	12	48	Дунд
Үйлдвэрийн ойр орчинд ил задгай гал алдсанаас ургамлан нөмрөг устгах	6	2	2	2	12	48	Дунд
ШТС-аас санамсаргүй байдлаар шатахуун алдагдсанаас хөрс бохирдох, хүнд металын бохирдолт үүсэх болзошгүй	6	2	1	2	11	44	Дунд
<b>Үр дүн (ерөнхий дундаж)</b>						50	Дунд

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх хамгийн их сөрөг нөлөөлөл нь хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөлөл байн

## 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

### Нийгэм, эдийн засагт нөлөөлөх нөлөөлөл

Тус төсөл хэрэгжсэнээр 43 хүнийг ажлын байраар тогтмол хангахаас гадна улс орон нутгийн төсөвт холбогдох татвар, төлбөрүүдийг төлнө.

Төслөөс нийгэм эдийн засагт үзүүлэх эерэг нөлөөллийн үнэлгээ

Үндсэн үзүүлэлт	Эрчим	Үргэлжлэх хугацаа	Хамрах хүрээ	Магадлал	Нийт оноо	Онооны эзлэх хувь %	Нөлөөллийн зэрэг
АМНАТ /ОН-ын төсөвт/	8	4	2	5	19	86	Их
НӨАТ	6	4	2	5	17	72	Дунд
ААНОАТ	6	4	2	5	17	72	Дунд
ХАОАТ	8	4	2	5	19	86	Их
Тусгай зөвшөөрлийн төлбөр /ОН-ын төсөвт/	6	4	2	5	17	72	Дунд
ЭМ, НДШ	6	4	2	5	17	72	Дунд
Газар ашигласны төлбөр /ОН-ын төсөвт/	8	4	2	5	19	86	Их
Ус ашигласны төлбөр /ОН-ын төсөвт/	6	4	2	5	17	72	Дунд
Автомашин, ө.я хэрэгслийн албан татвар	2	4	2	5	13	52	Дунд
Эрчим хүчний хангамж	6	4	1	4	15	60	Дунд
Усан хангамж	6	4	1	3	14	50	Дунд
Шинээр ажлын байр бий болох	6	4	2	5	17	72	Дунд
Бүтээгдэхүүн үйлдвэрлэл	8	4	2	5	19	86	Их
<b>Үр дүн (ерөнхий дундаж)</b>						<b>67.8</b>	<b>Дунд</b>

Уг төсөл хэрэгжсэнээр улс орон нутгийн төсөвт мөнгөн орлого төвлөрүүлэх ба нутгийн иргэдэд ажлын байр бий болгох зэрэг нийгэм эдийн засгийн хувьд эерэг нөлөөлтэйгөөс гадна Монгол орны хэмжээнд их хэмжээгээр хуримтлагдсан химийн хортой болон аюултай бодисын сав баглаа боодлын байгаль орчин, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад чухал үүрэгтэй юм.

**4. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ДАГУУ ХИЙСЭН АЖЛУУД**

**4.1 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар хийсэн ажлын биелэлт**

№	Хийгдэх ажил	Хариуцсан албан тушаалтан	2022 оны төлөвлөгөөний биелэли	Биелэлтийн хувь
1	Авто гээврийн хэрэгслээс үүсэх хорт хийн ялгарлыг бууруулахын тулд ашиглагдаж байгаа гээврийн хэрэгсэлд утааны шүүлтүүрүүдийн бүрэн бүтэн байдлыг шалгаж, тос, маслыг тогтоосон хугацаанд нь сольж байна.	Механик инженер	250 мот/цаг тутамд тээврийн хэрэгслүүдийн тос, маслыг солиж техникийн үзлэгийн дэвтэрт тэмдэглэж бүртгэв	100%
2	Агаарын тоосжилтыг бууруулах зорилгоор дотоод тээврийн замыг тогтмол услаж байна.	Механик инженер	Тоосжилтыг бууруулах зорилгоор хашааны гадна талд 500м, дотор талд 500м замыг тээвэрлэлтээс шалтгаалан сард 2-3 удаа тогтмол усалгаа арчигааг тогтмол хийж байна. Зардал 307 200 төгрөг.	100%
3	Мөн агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг тогтоох, бууруулахын тулд хяналт шинжилгээг тогтмол хэрэгжүүлнэ.	Механик инженер	Хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгасан агаарын шинжилгээг жилд 1-2 удаа хийж ЦУОШГ-н Байгаль орчин хэмжил зүйн төв лабораторт шинжлүүлж хариуг хавсралтаар хавсаргав.	100%
4	Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн дагуу ашиглагдаж байгаа тоног төхөөрөмжүүдийнхээ төлбөрийг төлнө.	Механик инженер	Агаарын бохирдлын төлбөрт 28500 төгрөг төлж бүртгүүлэв.	100%
Нийт 335 700 төг				

4.2 Усан орчинд үзүүлж буй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

№	Хийгдэх ажил	Хариуцсан эзэн	2022 оны төлөвлөгөөний биелэлт	Биелэлтийн хувь
1	Ca, Mg, Cl, SO <sub>4</sub> , NO <sub>2</sub> , NO <sub>3</sub> , NH <sub>4</sub> , HCO <sub>3</sub> , Fe, As, Na, K, Cd, Cu, Pb, Zn, Cr, Ni, Ag, Al, B, Ba, Mg, Mn, Se, Sr, Mo, Co, Be, Sb, Ca-ийнагууламж, амт, үнэр, өнгө, pH, нийт ууссан хатуу бодисын хэмжээ, нийт хатуулагийг үйлдвэрт ашиглаж буй усанд лабораторын шинжилгээ хийлгэх	Төслийн удирдагч	Жилд 1 удаа гүний худгаас усний дээж авч ЦУОШГ-н Байгаль орчин хэмжил зүйн төв лабораторт шинжлүүлж хариуг хавсралтаар хавсаргав. Төсөвт өртөгт 43000 төгрөг зарцуулав.	100%
2	Үйлдвэрийн нийт усны хэрэгцээ, эргүүлэн ашиглах усны хэмжээг зорилтод түвшинд байлгах.	Төслийн удирдагч	Ус ашиглах дүгнэлтийг Аймгийн БОАЖГ-р гаргуулан Усны гэрээг сумын Засаг даргатай байгуулан үйлдвэрийн нийт усны хэрэгцээ хэмжээг тодорхойлуулан баталгаажуулсан. Үйлдвэрлэлд хэрэглэсэн хаягдал усыг шламаас салган тунгааж 70-80%-ийг тунгаагуураар дамжуулан дахин ашиглаж эргэлтэнд оруулсан. Усны зохистой ашиглалтын талаар сургалтыг нийт ажилчин албан хаагчдад 2 удаа зохион байгуулсан. БОАЖЯ-ны сайдын 2018 оны 10-р сарын 2-ны өдрийн А/376 тоот тушаалаар баталсан ус ашиглуулах дүгнэлт гаргах үйлчилгээний хөлс 50000 төгрөг болон сургалт ажлын зардалд 500 000 төг зарцуулав.	100%
3	Усны зохистой ашиглалтын талаар сургалт явуулах.			
	Нийт зардал		543 000 төг	



4.3 Газар, хөрсний элэгдэл, эвдрэлд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арга хэмжээний биелэлт

№	Хийгдэх ажил	Хариуцсан	2022 оны төлөвлөгөөний биелэлт	биелэлт
1	Шимт хөрсний хими, физик шинж чанар болон хүнд металлын (Cr, Cd, Pb, Ni, Zn) агууламжийг лабораторын шинжилгээ хийлгэх	Төслийн удирдагч	Жилд 1 удаа Үйлдвэрийн хашаанаас хөрсний дээжийг авч ЦУОШГ-н Байгаль орчин хэмжил зүйн төв лабораторт шинжлүүлж хариуг хавсралтаар хавсаргав.	100%
2	Хөрсийг хамгаалж мод тарих ургамалжуулалт, ногоон байгууламжийн ажил үргэлжлэн хийгдэнэ.	Төслийн удирдагч	Үйлдвэрийн хашаанд тохижилтын ажил хийж улиас, хайлаас, бургас, голт бор, шар хуайс зэрэг модны 120ш үрсэлгээг ой мод үржүүлгийн мэргэжлийн байгууллагаас зөвлөсний дагуу авч тариалан зохих арчилгааг хийсэн ба усалгааны системийг бүрэн шийдвэрлэсэн. Үйлдвэрийн хашааны 0.07 га талбайн ногоон байгууламжид тариалсан олон наст согоовор, ерхөгийг арчлах, модлог ургамал болох хайлаас, шар хуайс, улиасны усалгаа хийх ажлыг хуваарьт өдрүүдэд тогтмол хийж, өнгө үзэмжийг сэргээсэн. Мөн 6 төрлийн цэцгийн мандлыг оффисын гадна хийж тариалсан. Нийт зардал 3 500 000 төгрөг	100%
3	Засварын газраас өөр газарт тос масло асгарсан тохиолдолд асгарсан хэсгийг элс асгаж саармагжуулан бохирдсон хөрсийг авч хог хаягдалруу ачуулна.	Төслийн удирдагч	Засварын газраас өөр газарт тос масло асгарсан тохиолдол гараагүй ба Асгаралтын иж бүрдэлд зориулж 240л багтаамжтай, Дугуйтай, түрж явах боломжтой, бохирдсон материал хийх даац сайтай зориулалтын хогийн сав 1ш, хамах хүрз тосгуур шүүрийг шинээр бүрдүүлэн ажилав. Ажлын зардал 250 000 төг	100%
	Нийт зардал		3 795 000 төг	

4.4 Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	Хийгдэх ажил	Хариуцсан эзэн	2022 оны төлөвлөгөөний биелэлт	Хувь
1	Олон салаа зам гаргахгүй байх	Төслийн удирдагч	Үйлдвэрийн хашааны дотор болон хашааны гаднах замын зургийг гаргаж 1:2000М-тай үйлдвэрийн хашааны зургийн хамт Ландтест ХХК-р гаргуулсан. Олон салаа зам гаргахаас сэргийлж жолооч нарт сургалт 1 удаа хийсэн.	100%
2	Гал түймрийн аюулаас хамгаалж гал унтраах багаж хэрэгслийг кемпд байгуулах	Төслийн удирдагч	Галын аюулгүй байдлын дүгнэлтийг холбогдох газраар гаргуулж гал унтраах тоног төхөөрөмж анхан шатны багаж хэрэгсэлыг байрлуулж галын аюулаас сэргийлэх талаар анхан шатны арга хэмжээний талаар таниулах самбар байрлуулсан.	100%
3	Үйлдвэр орчмын ургамлын бүрхэц, зүйлийн бүрдлийн судалгаа	Төслийн удирдагч	Энэ ажлыг Цавчирын хөндий ХХК-н мэргэжилтнүүдийн хамт хийж гүйцэтгэсэн.	100%
4	Шимт хөрсний хими, физик шинж чанар болон хүнд металлын (Cr, Cd, Pb, Ni, Zn) агууламж тодорхойлох шинжилгээ	Төслийн удирдагч	Үйлдвэрийн хашаанаас хөрсний дээжийг авч ЦУОШГ-н Байгаль орчин хэмжил зүйн төв лабораторт шинжлүүлж хариуг хавсралтаар хавсаргав.	100%
	Нийт		960 000 төгрөг	

**4.5 Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө**

№	Хийгдэх ажил	Хариуцсан эзэн	2022 оны төлөвлөгөөний биелэлт	хувь
1	Төслийн талбайн орчинд хээрийн судалгаа хийх	Төслийн удирдагч	Энэ ажлыг Цавчирын хөндий ХХК-н мэргэжилтнүүдийн хамт хийж гүйцэтгэсэн.	100%
2	Үйлдвэрийн хашаанд орж ирсэн амьтныг мэргэжлийн байгууллагад мэдэгдэжарга хэмжээ авах	Төслийн удирдагч	Үйлдвэрийн хашаанд амьтан орж ирэхээс хамгаалан бүрэн бүтэн байдалд анхаарч 200м хашаанд засвар хийж битүүлэв.	100%
	Нийт		600 000	

## 5. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Хог хаягдлын талаар хийгдэх ажлууд	Хариуцсан эзэн	2022 оны төлөвлөгөөний биелэлт
1	Ахуйн шингэн болон хатуу хог хаягдал хаях цэгээ сумын засаг даргаар тогтоолгоно.	Төслийн удирдагч	Газар ашиглах болон ус ашиглах гэрээг Сумын Засаг даргатай байгуулж гэрээнд заасан үүргийн дагуу ахуйн шингэн болон хатуу хог хаягдлыг хаях цэгийг тогтоон тохижуулж ажилласан. Цаашид тохижилтын ажлыг үе шаттай үргэлжлүүлэн хийнэ.
2	Ахуйн хог хаягдлаа заасан газарт тээвэрлэн хаяна	Төслийн удирдагч	Ахуйн хог хаягдлыг өөрийн тээврээр сард 1 удаа тээвэрлэн хаяж байна.
3	Ахуйн шингэн болон хатуу хог хаягдлын хэмжээг тогтоож суманд улирал тутамд мэдээллэж байна.	Төслийн удирдагч	Хог тээвэрлэлтийн болон үйлдвэрийн 10 ажилчин ажиллаж байгаа бөгөөд сард ойролцоогоор 24 кг хатуу бохир хаягдал, шингэн хаягдал 4.6 м <sup>3</sup> гарч байгаа. Аймаг сумын БО-ны газарт мэдээ тайланг байнга өгдөг ба Аймгийн МХГ-с шалгалт хийгддэг.
4	Машин механизмын засвараас гарах ашигласан тос маслыг эрх бүхий байгууллагад шилжүүлнэ.	Төслийн удирдагч	Улаанбаатар хотын Багануур дүүрэгт байрлах “Алтан оршихуй” ХХК-д 1 удаагийн тээврээр 120л тос өгсөн.
5	Ариутгал халдваргүйжүүлэх, задлах бодис худлдан авах	Төслийн удирдагч	2022 оны 3 сард Ариутгал халдваргүйжүүлэх бодис 50ш-г худалдан авч ажилчидад тараасан. 10 кг хлорын шохойг авч нөөцөлсөн.
6	Кемпд ахуйн хэрэгцээнд ашиглах түлээ сонгохдоо түүхий нүүрс ашиглахгүй байх	Төслийн удирдагч	Түүхий нүүрс ашигладаггүй.
7	Дахин ашиглах түүхий эдийг ялган боловсруулах		Дахин ашиглах түүхий эдийг ялган өөрийн үйлдвэрт боловсруулдаг.
9	Нийт зардал		350000Т

Хог хаягдлын менежментийн ажлын хүрээнд 2 удаа бүх нийтийн субботник зохион байгуулж Үйлдвэрийн хашаанаас 50м зайн бүх хог хаягдлыг цэвэрлэн 2 портер хогийг тээвэрлэн цэвэрлэсэн.

## 6. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

БОННУ-ний тайланд Энэхүү төслийн хувьд “Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө”-г тусгайлан боловсруулах шаардлагагүй гэж дүгнэсэн.

**7. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭ**

Арга хэмжээ	Хамрах хүрээ	Хариуцан хэрэгжүүлэгч	2022 оны төлөвлөгөөний биелэлт
Төслийг хэрэгжүүлэх хугацаанд БОННУ-ний тодотголыг хуулийн хугацаанд хийлгэх	Төслийн хүрээнд	"Түмэн Эгшиг" ХХК	Тодотгол хийх мэрэгжилийн байгууллагын судалгааг хийсэн. Хуулийн хугацаа болоогүй байгаа.
Үйлдвэрийн ажилчдад байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг хамгаалах талаар сургалт зохион байгуулах	Үйлдвэрийн ажилчид	"Түмэн Эгшиг" ХХК	Үйлдвэрийн ажилчдад байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг хамгаалах талаар сургалт 1 удаа зохион байгуулсан. Сургалтыг Монголын хог хаягдлыг дахин боловсруулах үндэсний холбоотой хамтран хийсэн.
БҮГД			250000

**8. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ АЖЛЫН 2022 ОНЫ БИЕЛЭЛТ**

БОМТ хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээллийн агуулга	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	1 жил шаардагдах зардал /мян.төг/
<ul style="list-style-type: none"> <li>Сэргэлэн сумын Засаг дарга, ИНХ, холбогдох бусад байгууллага, ажилтнууд;</li> <li>Сум, багийн оршин суугчид</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Уулзалт, ярилцлага зохион байгуулах;</li> <li>Хурал, зөвлөгөөн зохион байгуулах;</li> <li>Санал асуулгын хуудас ашиглах г.м.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Төслийн үйл ажиллагааны талаарх мэдээлэх;</li> <li>“Байгаль орчны менежментийн төлөвлөгөө”-ний хэрэгжилтийн талаарх мэдээлэх;</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Хэлэлцүүлэг хийх сэдвээр холбогдох байгууллага, хүмүүст урьдчилан тодорхой мэдээлэл хүргэх;</li> <li>Харилцан ярилцах;</li> <li>Санал асуулга авах;</li> </ul>	200 000
<b>Нийт зардал</b>	<b>200 000</b>			

2022 онд Сумын Засаг даргын тамгын газарт 5 удаа уулзалт хийж үйлдвэрийн үйл ажиллагаа, байгаль орчны талаар хийж хэрэгжүүлж байгаа ажлуудын талаар болон нийгмийн хариуцлагын



хүрээнд хийх ажлуудын талаар уулзалт хийсэн. Компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд, Сэргэлэн сумын ЗДТГ-тай хамтран ажиллах гэрээ байгуулж 10 сая төгрөгийг сумын ногоон байгууламж, мод тарих үйл ажиллагаанд хандивласан.

Мөн сумын ахмад настан 9 иргэний амралт сувилалын зардал болох 1500 000 төгрөгийг компаниас дааж Хөвсгөл аймгийн амралт сувилалд хамруулсан.

Баянбүрд багийн Засаг дарга Батсайхан болон багийн иргэдийн төлөөл үйлдвэрийн үйл ажиллагаа, байгаль орчны талаар хийж хэрэгжүүлж байгаа ажлуудын талаар танилцаж санал солилцсон. Аймгийн МХГ болон байгаль орчны албаны хүмүүс ээлжит шалгалтаар ирж санал дүгнэлт гаргаж мэргэжлийн зөвөлгөө өгсөн.

### **9. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР**

#### ***1. Агаарын чанарын мониторинг***

Агаарын чанарын зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрэх тохиолдлыг шалгах, хэмжилтийн мэдээний жилийн бичилт динамикийг гаргах зорилгоор агаар орчны тоосны агууламж, органик бус хийн төлөвт бохирдуулагчид (хүхрийн исэл, азотын давхар исэл, нүүрстөрөгчийн дан исэл), тоосны хуримтлалыг хянах зорилгоор дээж авч ЦУОШГ-н Байгаль орчин хэмжил зүйн төв лабораторт Агаарын чанарын стандарт MNS 4585: 2016 20 минутын хэмжилтээр шинжлүүлж тодорхойлуулахад хорт бодисын хэмжээ болон нийт нарийн ширхэгт тоосны хэмжээ хэвийн үзүүлэлттэй гарсан. Шинжилгээний хариуг хавсралтаар үзүүлэв.

#### ***2. Усан орчны мониторинг***

Үйлдвэрт ашиглаж байгаа усны чанарыг хянах зорилгоор Үйлдвэрийн гүний худгаас дээж авч авч ЦУОШГ-н Байгаль орчин хэмжил зүйн төв лабораторт шинжлүүлэхэд MNS 0900: 2018 стандартад заасан 10 үзүүлэлт тус бүр хэвийн хэмжээнд байгаа үзүүлэлттэй байсан.

Шинжилгээний хариуг хавсралтаар үзүүлэв.


Мөн худгийн усанд цэвэр усны чанарын шинжилгээг ЦУОШГ-н Байгаль орчин хэмжил зүйн төв лабораторт хийлгэж MNS 0900: 2018 стандарт үзүүлэлтийг хангаэ байгааг тодорхойлуулсан. Шинжилгээний хариуг хавсралтаар үзүүлэв

#### ***3. Хөрсөн бүрхэвчийн мониторинг***

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсэг болох орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт хөрсний хяналтын цэгүүдээс дээж авч мэргэжлийн итгэмжлэгдсэн лабораториор шинжилгээ хийлгэхээр тусгасан байдаг. Бид энэ ажлын хүрээнд хөрсний хими, физик шинж чанар болон хүнд металлын (Cr, Cd, Pb, Hg, Zn, Cu, Co, Sr ) агууламжийг хянахаар дээж авч ЦУОШГ-н Байгаль орчин хэмжил зүйн төв лабораторт шинжлүүлэхэд MNS5850:2019 стандартад заасан хэмжээнээс бага үзүүлэлттэй гарсан.

**2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ  
ЗАРДЛЫН ХҮСНЭГТ**

Д/д	Авч хэрэгжүүлэх төлөвлөгөө	Төлөвлөсөн төсөв, ₮	Зарцуулсан зардал, ₮
1	<i>Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө</i>	335700	335700
2	<i>Усан орчинд үзүүлж буй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө</i>	543000	543000
3	<i>Газар, хөрсний элэгдэл, эвдрэлд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арга хэмжээний төлөвлөгөө</i>	895000	3 795 000
4	<i>Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө</i>	960000	960000
5	<i>Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө</i>	600000	600000
7	<i>Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө</i>	500000	550 000
8	<i>Удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ</i>	250000	250 000
9	<i>Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр төсөв</i>	201000	220 000
10	<i>Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах төсөв</i>	200000	200 000
	<b>БҮГД</b>	<b>4 984 700</b>	<b>7 453 700</b>



ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР  
БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН  
ТӨВ ЛАБОРАТОРИ

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж,  
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас: 11-341818  
E-mail: [bohzt@gmail.com](mailto:bohzt@gmail.com)



СОРИЛТЫН ДҮН

Дугаар он/№ : 2022/A-341  
 Дээжийг ирүүлсэн газрын нэр, хаяг, утас : "Түмэн Эгшиг" ХХК  
 Дээжийг авсан хүний нэр, албан тушаал : Д.Сувд агаарын хэсэг  
 Дээжийн тоо, төрөл : 1 агаар, 1 дуу чимээ  
 Сорьц авсан огноо : 2022.11.01  
 Дээжийн тодорхойлолт : Төв аймаг Сэргэлэн сум хуванцарын үйлдвэр  
 Шинжилгээний аргын стандарт : MNS 0017-2-5-12:2021, MNS 0017-2-5-11:2021  
 Шинжилсэн огноо : 2022.11.03  
 Хуудасны тоо : 1/1  
 Үр дүн :

№	Сорьц авсан цэг	Сорьц авсан өдөр	Сорьц авсан цаг	Хүхэрлэг хий мг/м <sup>3</sup>	Азотын давхар исэл мг/м <sup>3</sup>	Нийт Тоос /TSP/ мг/м <sup>3</sup>	Дуу чимээ /ДБА/
1	Үйлдвэрийн хашаан дотор	XI/01	13:50	0.015	0.023	0.066	44
Агаарын чанарын стандарт MNS 4585:2016 (20 минутын хэмжилт)				0.450	0.200	0.500	60

Шинжилгээ гүйцэтгэсэн:  
Агаарын хэсгийн инженер

Хянаж баталгаажуулсан:  
Агаарын хэсгийн инженер




Э.Оюунтуяа

Д.Түмэндэлгэр

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.  
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй





ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР  
БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН  
ТӨВ ЛАБОРАТОРИ

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж,  
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас: 11-341818  
E-mail: [bohzt@gmail.com](mailto:bohzt@gmail.com)



СОРИЛТЫН ДҮН

Дугаар он/№	: 2022/ Ц-206
Сорьцыг ирүүлсэн газрын нэр, хаяг, утас	: “Түмэн Эгшиг” ХХК
Сорьцыг авсан хүний нэр, албан тушаал	: Д.Сувд, БОХЗТЛ
Сорьцын тоо, төрөл	: 1, ус
Сорьцыг авсан огноо	: 2022.11.01
Сорьцын тодорхойлолт	: Усны сорьц
Шинжилгээний аргын стандарт	<b>MNS ISO 10523:2001, MNS ISO 7888:1999, MNS 6271:2011, MNS 4424:2005, MNS 1097:1970</b>
Шинжилсэн огноо	: 2022.11.01-2022.11.04
Хуудасны тоо	: 2 /2
Үр дүн	: 1

Сорьцын нэр	pH	EC µS/cm	SO <sub>4</sub> мг/л	Cl мг/л	Ca мг/л	Mg мг/л	Na+K мг/л	HCO <sub>3</sub> мг/л	Эрд мг/л	Хат мг-экв/л
Төв аймаг Сэргэлэн сум Хуванцарын үйлдвэр Гүний худаг	8.10	313	35.6	10.4	47.9	8.9	17.2	170	290	3.13
<b>MNS 0900:2018</b>	<b>6.5-8.5</b>	<b>1000</b>	<b>500</b>	<b>350</b>	<b>100</b>	<b>30</b>	-	-	-	<b>7.0</b>

Тайлбар: EC - цахилгаан дамжуулах чанар, Хат-Хатуулаг, Эрд-Эрдэсжилт

Шинжилгээ гүйцэтгэсэн инженер:

Б.Жавзандулам


Хянаж баталгаажуулсан инженер:

Ц.Мийдүв



Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.  
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй.





**ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР  
БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН  
ТӨВ ЛАБОРАТОРИ**

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж,  
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас: 11-341818  
E-mail: [bohzt@gmail.com](mailto:bohzt@gmail.com)



**СОРИЛТЫН ДҮН**

Дугаар он/№ : 2022/ Ц-206  
 Сорьцыг ирүүлсэн газрын нэр, хаяг, утас : “Түмэн Эгшиг” ХХК  
 Сорьцыг авсан хүний нэр, албан тушаал : Д.Сувд, БОХЗТЛ  
 Сорьцын тоо, төрөл : 1, ус  
 Сорьцыг авсан огноо : 2022.11.01  
 Сорьцын тодорхойлолт : Усны сорьц  
 Шинжилгээний аргын стандарт **MNS ISO 6836:2020, MNS 6833:2020**  
**MNS ISO 7150-1:2006, MNS 6779:2019**  
**MNS 6834:2020, MNS ISO 6878:2001**  
**MNS 4430:2005, MNS 6272: 2011**  
 Шинжилсэн огноо : 2022.11.01-2022.11.04  
 Хуудасны тоо : 1 /2  
 Үр дүн : 1

Сорьцын нэр	Ж/б мг/л	ПИЧ мг/л	NH <sub>4</sub> -N мгN/л	NO <sub>2</sub> -N мгN/л	NO <sub>3</sub> -N мгN/л	PO <sub>4</sub> мгP/л	Fe мг/л	F мг/л
Төв аймаг Сэргэлэн сум Хуванцарын үйлдвэр Гүний худаг	0.2	0.8	0.26	0.002	0.08	0.017	0.13	1.15
<b>MNS 0900:2018</b>	-	-	<b>1.5</b>	<b>1.0</b>	<b>50</b>	<b>3.5</b>	<b>0.3</b>	<b>0.7-1.5</b>

Тайлбар: Ж/б- Жинлэгдэгч бодис, ПИЧ-Перманганатын Исэлдэх Чанар

Шинжилгээ гүйцэтгэсэн инженер

Б.Жавзандулам


Хянаж баталгаажуулсан инженер

Ц.Мийдүв



Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.  
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй.





**ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР  
БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН  
ТӨВ ЛАБОРАТОРИ**

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж,  
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас: 11-341818  
E-mail: bohzt@gmail.com



**СОРИЛТЫН ДҮН**

Дугаар он/ № : 2022/ 711  
 Дээжийг ирүүлсэн газрын нэр, хаяг, утас : “Түмэн эгшиг” ХХК  
 Дээжийг авсан хүний нэр, албан тушаал : Д.Сувд, агаарын хэсгийн техникч  
 Дээжийн тоо, төрөл : 1, хөрсний сорьц  
 Хүлээн авсан огноо : 2022.11.01  
 Дээжийн тодорхойлолт : Төв аймаг, Сэргэлэн сум, Хуванцар үйлдвэр  
 Шинжилгээний аргын стандарт : САЗ А01:2022  
 Шинжилсэн огноо : 2022.11.03  
 Хуудасны тоо : 1/1  
 Үр дүн:

№	Сорьц авсан цэгийн нэр	Кадьми (Cd)	Хар тугалга (Pb)	Мөнгөн ус (Hg)	Хром (Cr)	Цайр (Zn)	Зэс (Cu)	Кобальт (Co)	Стронци (Sr)
1	Хашаан дотроос	<0.005	17.0	<0.005	<0.005	62.3	27.0	20.9	247.0
	<b>MNS 5850:2019 / ЗДХ/</b>	<b>3</b>	<b>100</b>	<b>2</b>	<b>150</b>	<b>300</b>	<b>100</b>	<b>50</b>	<b>800</b>

Шинжилгээ гүйцэтгэсэн : Д.Баярхулан  
 Хөрсний хэсгийн инженер

Хянаж баталгаажуулсан : Б.Даваасүрэн  
 Хөрсний хэсгийн инженер



Хуулбарлан хэрэглэхийг хориглоно  
 Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн дээжинд хүчинтэй



